



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/13

Чингис хот

Хяналт шалгалт зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.13 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны “Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын журам” 318 дугаар тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2014 оны “Журам батлах тухай” А-166 дугаар, 2020 оны “Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай” А/577 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар бэлтгэгдэж буй Өмнөдэлгэр, Батширээт сумдын ойн сангийн талбай, самар бэлтгэж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил зохион байгуулахад шаардагдах 2690000 /хоёр сая зургаан зуун ерэн мянган/ төгрөгийн хөрөнгө за эцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хяналт шалгалтын ажлын удирдамж, бүрэлдэхүүнийг батлуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг тагилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантөр/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/ нарт даалгасугай.

4. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010056

Аймгийн Засаг даргын 2021 оны
...01... дугаар сарын 12... өдрийн А/13...
дугаар захирамжийн хавсралт



Зардлын тс оцоо

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт зардал /төгрөг/
1	Томилолт	10 хүн 6 хоног	26500	1590000
2	Шатахуун	А-92 - 690 л Масло - 2 л		1100000
Нийт зардал				2690000